

The Defacto Gazette

Мэдээлнэ. Зоригжуулна. Мэдэлжүүлнэ.

АГУУЛГА

МОНГОЛ, АНГЛИ ХЭЛ ДЭЭР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН NO. 24 ЛХАГВА, 2017.12.06 WWW.DEFACTO.MN

DeFacto Мэтгэлцээн

Сэдэв: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо буруу

Дэмжигч талаас:
Трансперенси Интернешнл Гүйцэтгэх Захирал О.Батбаяр
Ерөнхийлөгчийн зөвлөх Ж.Амарсанаа

Няцаагч талаас:
ХНХЯ-ны Ахлах мэргэжилтэн А.Хишигбаяр
ЭМЯ-ны Бодлогын газрын мэргэжилтэн О.Батбаяр

Монголд зарж буй эм, эмнэлгийн хэрэгслийн гуравны нэг нь хуурамч. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар Монгол улсад зарагдаж буй нийт эмийн гучаад хувь нь чанаргүй буюу бүртгэгдээгүй байдаг ажээ, Хуудас 1

НИЙТЛЭЛ

- 1 Эрүүл биш эрүүл мэндийн тогтолцоо

ЯРИЛЦЛАГА

- 3 А.Билгүүн
"MIBG" үнэт цаасны компанийн гүйцэтгэх захирал




А.Билгүүн

"MIBG" үнэт цаасны компанийн гүйцэтгэх захирал

Гадаадын хөрөнгө оруулагчид манайд ирснээрээ жилдээ 50–100 хувийн хөрөнгө оруулалтын өгөөж шаардаж байгаа бөгөөд үүнийг гаргаж чадах цорын ганц салбар нь уул уурхай, тэр тусмаа хайгуулын салбар байгаа юм, Хуудас 3

ТОЙМ

- 5 Дэлхийн банк 120 сая долларын санхүүжилт баталлаа
С.Зоригийн хэргийг нууцаас гаргана
Банкуудын хөрөнгийн доод хэмжээг шинэчлэв
Монголбанкны Ерөнхийлөгч асан Н.Золжаргалыг баривчилжээ




Гар утасны аппликэйшн, Jargal DeFacto



Гэрэл зургийг: unaid.org

Дэлхийн банк Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор 120 сая долларын санхүүжилтийг баталлаа, Хуудас 5



Гэрэл зургийг: news.mn

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10-р сарын 30-ны өдрийн шийдвэрээр банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөс 100 тэрбум төгрөг болгожээ, Хуудас 6

Та "Дефакто Газет" цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонбаярын Наранцацрал
Өсөхбаярын Биндэрьяа
Адьяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ:

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976-94109342
🌐 www.defacto.mn



408

Д.Жаргалсайхан

Долоо хоног бүрийн нийтлэл, jargaldefacto.com/category/23

Эрүүл биш эрүүл мэндийн тогтолцоо

Эрүүл мэндийн салбарыналь хэсэгт, ямар түвшинд авлига байгаа, авлигын суурь шалтгаан нь юу болох талаар мэдээлэлтэй хэлэлцэх шаардлага эдүгээ монголын нийгэмд үүсээд байгаа юм. Яг энэ зорилгоор Дефакто институцаас телевизийн ээлжит мэтгэлцээнээ 12 дугаар сарын 1-нд зохион байгуулав. Мэтгэлцээнийг 2014 онд Азийн Сангаас хараат бус, төрийн бус байгууллагаар хийлгэсэн “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдлын судалгаа”-ны дүнг танилцуулж эхлүүлэв. Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдлын тухай энэхүү судалгаанд нийслэлийн гурван шатлалын 18 эмнэлэг, эдгээрт нэгээс доошгүй жил ажилласан 200 эмч сувилагч болон хоёр долоо хоногоос багагүй хугацаагаар үйлчлүүлсэн 700 үйлчлүүлэгчийг хамруулжээ. Хамрагдагсдын 55 хувь нь ямар нэг байдлаар эмч, эмнэлгийн ажилтанд бэлэг сэлт өгсөн гэж хариулснаас, 23 хувь нь үйлчлүүлэгч өөрөө, 32 хувь нь ар гэрийнхэн нь өгсөн гэжээ.

Мэтгэлцээнд урьдчилан тохиролцсоны дагуу Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэргэжилтнүүд орох байсан ч эхлэхээс хэдхэн хоромын өмнө татгалзав. Монгол төрийн ажилтнууд, удирдлага нь олон нийтэд мэдээлэл өгөх үндсэн үүргээ үл ойшоодгийн тод жишээ нь энэ. Угаасаа Засгийн газар жил хагас болоод л солигдож, дагаад ажилтнууд нь өөрчлөгддөг учраас чадваргүй, ажлаа мэддэггүй, хүнд сурталтай, хариуцлагаас зугтдаг этгээдүүд олширсоор байна.

Монголд зарж буй эм, эмнэлгийн хэрэгслийн гуравны нэг нь хуурамч. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар Монгол улсад зарагдаж буй нийт эмийн гучаад хувь нь чанаргүй буюу бүртгэгдээгүй байдаг ажээ,

Харин Транспэрэнси Интернэшнл Монгол байгууллагын Гүйцэтгэх захирал О.Батбаяр болон Ерөнхийлөгчийн зөвлөх, АУ-ны доктор Ж.Амарсанаа нар цагтаа ирж, олон нийтийг хүндэтгэн, мэтгэлцээнд идэвхтэй оролцлоо. Төрийн ажилтнууд ирээгүй болохоор бид гурав мэтгэлцээн гэхээсээ илүү хэлэлцүүлэг өрнүүлсний гол санааг нэгтгээд доор сийрүүлэв.

Салбарын санхүүжилт

2016 оны байдлаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийн бүтцийг авч үзвэл эрүүл мэндийн даатгалын сангаас 20 хувийг, төсвөөс 40 хувийг, үлдсэн 40 хувийг хувь хүмүүс өөрсдөө төлдөг болжээ. Хувийнхаа зардлаар төлж байгаа хэсэг нь ийм өндөр байгаа учир МУ-ын иргэд буцаад ядууралд өртөх эрсдэл өндөр байгааг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас онцолсон байна. Олон улсын жишгээр бол эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5–10 хувийг зориулахыг хэвийн гэж үздэг бол манайд 3–4 хувь байгаа ажээ.

Эрүүл мэндийн зориулалтын зарцуулалтыг нэмэхдээ өгөөжийг нь сайжруулах, хяналтын механизмыг, түүний дотор иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай байна. Тэгэхгүй бол мөнгө хөрөнгө ёроолгүй сав шиг урссаар, иргэдээ хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр хангаж чадахгүй юм.

Эм ба эмчилгээний гажуудал

Улаанбаатар хотод хаа сайгүй эмийн сан олширч, жоргүйгээр эм олгох болсноор иргэд хоол биш эм иддэг болжээ. Монголд зарж буй эм, эмнэлгийн хэрэгслийн гуравны нэг нь хуурамч.





Транспэрэнси Интернэшнл Монгол байгууллагын Гүйцэтгэх захирал О.Батбаяр



Ерөнхийлөгчийн зөвлөх, АУ-ны доктор Ж.Амарсанаа

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар Монгол улсад зарагдаж буй нийт эмийн гучаад хувь нь чанаргүй буюу бүртгэгдээгүй байдаг ажээ. Монгол улс эмийн зохисгүй хэрэглээ өндөртэй орны тоонд орох боллоо.

Энэ оны аравдугаар сарын байдлаар эмийн үнийн хөнгөлөлтөд зориулж төр засгаас 26.3 тэрбум төгрөгийг эмийн сангуудаар дамжуулан олгосон байна. Энэхүү эмийн хөнгөлөлтөд нийгмийн даатгалын сангаас олгосон мөнгөний 15 орчим хувийг зориулжээ. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар манай улс эмийн үнэ өндөр дэлхийн арван орны тоонд бас багтаж байна.

Иргэд ажил олгогчоороо дамжуулж тогтмол эрүүл мэндийн даатгал төлдөг. Бас эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа дунджаар 50 хүртэл мянган төгрөгний төлбөр төлдөг. Дээр нь эмч, сувилагч нарын гарыг цайлгах ёстой. Хамгийн гол нь эм тариа чанаргүй бас маш үнэтэй байгаагаас болж иргэд өвдсөн тохиолдолд санхүүгийн хямралд ордог байна.

Азийн Сангийн эрүүл мэндийн салбар дахь авлигын судалгаагаар манай улсад жирийн эмч сувилагч, эмнэлгийн ажилчидтай холбоотой авлига гарч байгаа ч, суурь шалтгаан нь эмнэлгийн ажиллагсдын цалин хөлс бага, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж муу, чанар хангалтгүй байгаагаар холбоотой юм.

Бүх нийтэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх дэд бүтэц манайд бий болжээ. Гурван шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ бүрдсэн, хувийн эмнэлгүүд ажиллаж байгаа зэрэг нь харьцангуй давуу талууд. Хувийн эмнэлгүүд олноор бий болсон нь төр засгийн ачааллыг хуваалцаж байгаа ч хувийн хэвшлийн эмнэлгийн үйлчилгээнд төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй хөрөнгө мөнгөний зарцуулалтын хяналтыг сайжруулах, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Эрүүл мэндийн

даатгалын санг Эрүүл мэндийн яаманд шилжүүлж байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрөө өөртөө төлбөр өгөхөөр болж буй хэрэг учир иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байна.

Эрүүл мэндийн даатгалын санг Эрүүл мэндийн яаманд шилжүүлж байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрөө өөртөө төлбөр өгөхөөр болж буй хэрэг учир иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байна,

Иргэдийн хяналт

Монголчууд бид эдүгээ сайн хийж чадахгүй байгаа, өөрсдийнхөө эрүүл мэндийн төлөө заавал хийх нэг л чухал ажил бол “иргэдийн хяналт”.

Иргэд төлсөн даатгалаа яг юунд, яаж зарцуулж байгааг нь хянахгүй бол, мэдээллийг ил тод байлгахыг шаардахгүй бол энэ салбарын ямар ч асуудал шийдэгдэхгүй юм.

Уг нь иргэдийн одоо төлж байгаа даатгалыг улсад биш хувийн даатгалд төлбөл жилдээ 250–350 сая төгрөгний үйлчилгээ авах боломжтой. Нөгөө талаасаа төр засгийн зүгээс эрүүл мэндийн даатгал төлөгч хүн бүрт өөрсдийн төлсөн мөнгө нь юунд зарцуулагдаж байгааг хамгийн хялбараар, цахимаар харах боломжийг нээж өгөх нь ард иргэдийн оролцоотой хяналтын механизмыг сайжруулах чухал алхам болно.

Эрүүл мэндийн үйлчилгээний салбар болон эрүүл мэндийн даатгалын салбарт хувийн хэвшлийг нэвтрүүлснээр, хувийн хэвшилд үйлчилгээний төлбөрт төрөөс төлж буй урсгалыг хянахад иргэний нийгмийн оролцоог хангаж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бодит байдлыг чөлөөтэй цацсанаар эрүүл мэндийн салбарын үйлчилгээний үр өгөөжийг дээшлүүлэх юм.



ДЕФАКТО ЯРИЛЦЛАГА

Англи, монгол хэл дээрх ярилцлага, jargaldefacto.com/category/8

А.Билгүүн
“MIBG” үнэт цаасны компанийн гүйцэтгэх захирал

Ж: Танай компани Discover Mongolia үйл ажиллагааг 15 дахь жилдээ зохион байгуулж байна, үүний тухай товч танилцуулаач. Мөн монголын уул уурхайн салбарын өнөөгийн байдал, гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад болж байгаа болон болохгүй байгаа зүйлс юу байна вэ?

А.Билгүүн: Миний бие Discover Mongolia-г 2012 он хүртэл зохион байгуулсан бөгөөд түүнээс хойш зохион байгуулах хороонд нь зөвлөгөө өгч байна. Хамгийн анх зохион байгуулах санаагаа Торонто хотод болдог PDAC хурлаас авч Монголд хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор ийм үйл ажиллагаа зохион байгуулдаг больё гэж 2000-аад оны үед бодсон.

Ж: Анх монголын тухай мэддэггүй байсан бол одоо уул уурхайн том тоглогчид андахгүй болжээ. Гэхдээ энэ жилийн хувьд гадаад өрийн хэмжээ, эдийн засгийн хямралаас үүдээд байдал өөр байгаа. Уул уурхайн салбарт энэ яаж нөлөөлж байна вэ?

А. Билгүүн: Одоогийн байдлаар монголын уул уурхайн хоёр салбар руу хөрөнгө оруулж болж байна. Уул

уурхайн олборлогч компаниудын хувьцаа, бондыг худалдаж авах замаар гадна, дотны хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулж болно. Үүнээс гадна уул уурхайн хайгуулын салбар руу буюу ХХК-уудын хувьцааг худалдаж авах, мөнгө зээлэх замаар хөрөнгө оруулж болно. Хамгийн сонгодог арга нь монголд байгаа болон гадаадын (Торонто, Австрали г.м) хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргасан компаниудын хувьцааг худалдаж авах юм.

Ж: Хайна гэдэг амархан, харин хайсан юм болгоноо олно гэдэг хэцүү. Хэдэн сая доллараар хайгуул хийгээд юу ч олохгүй тохиолдол бий. Энэ талаар та юу хэлэх вэ?

А. Билгүүн: Миний бодлоор уул уурхайн хайгуулын салбар хөрөнгийн зах зээл дотроо хамгийн эрсдэлтэй салбарын нэг. Explanation inside гээд вебсайт дээр хайгуулын салбартай холбоотой мэдээллүүд их ордог. Брэд Күүк гэх геологичийн бичсэнээр манай Оюу толгой шиг мега төслийг юу ч байхгүй газар хайгаад олох нь 100 жилд 1 удаа тохиолдоно. Бороо Гоулд шиг нэг сая орчим унцын нөөцтэй алтны дундаж ордыг олох магадлал 1000-

д нэг гэсэн. Казиногийн рулет дээр хожих магадлалаас бага, адилхан гэсэн үг.

Ж: Нэг удаагийн өрөмдлөгөнд хэр их мөнгө орох вэ?

А. Билгүүн: Одоогийн зах зээлийн ханшаар 1 метр нь 100-200 доллар байгаа боловч энэ ямар төрлийн орд хайж байгаагаасаа шалтгаалаад ялгаатай. Оюу толгой шиг гүн ордыг дор хаяж 500-600 метр ухах хэрэгтэй байхад харьцангуй дээгүүр тогтдог ордуудыг 100-200 метр өрөмдөхөд хангалттай байна. 1 өрмийн цооног 100 метрт тогтооё гэхэд 20 мянган ам.доллар болно. Гэвч олон улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө босгох хэмжээнд хүрэхийн тулд дор хаяж 100 өрмийн цооногтой байх шаардлагатай болдог. Тэгэхээр наад зах нь 2 сая долларыг зарцуулж байж цааш нь байгаа эсэхийг тодорхойлох боломжтой болно гэсэн үг.

Ж: Анхны хайгуулаа хийгээд нөөц олсон жуниор буюу жижиг компаниудаас том компаниуд худалдаж авна уу гэхээс өөрсдөө хайгуул хийдэггүй. Монголын уул уурхайн хайгуул хийж байгаа компаниуд гадаадын хөрөнгө оруулалт татаж байгаа. Ингэхэд ямар асуудлууд гарч байна вэ?

А. Билгүүн: Үндэстэн дамнасан уул уурхайн корпорациуд болох BHB, Rio Tinto, Vale гэх мэт том компаниуд таны хэлсэнчлэн төсөл худалдаж авах аргаар нөөцөө бий болгодог. Уул уурхайн компаниуд харин одоогийнхоо ордыг ашиглаад дуусахад нөөц нь дахин сэргээгдэхгүй. Эдгээр компаниуд

ALL-NEW DISCOVERY

www.landrover.mn



Вагнер Ази Автомотив ХХК
Нарны зам 55/1, Тээвэрчид гудамж, Сүхбаатар дүүрэг, Монгол улс, 14253
Холбоо барих: 70113673, 99106507, 99118375, 99118301

WAGNER
ASIA AUTOMOTIVE LLC



эрсдлийг хүлээх сонирхолгүй байдаг тул эрсдэл хүлээдэг зориулалтын компаниудад хүлээлгэдэг. 2010 оноос Ерөнхийлөгчийн тамгын газраас хайгуулын зөвшөөрөл тусдаа гаргах, хуучин байсан хайгуулын зөвшөөрлийг шилжүүлэхийг хорьсон байдаг. Хорьсон шалтгаан нь хайгуулын зөвшөөрөл дээр тулгуурласан лицензийн наймаа, орон нутгийн иргэдийн дургүйцэл байсан байгаа юм. Тэгэхээр хайгаад шинэ орд олох боломжгүй болчихоор аливаа салбарт авьяасын ундарга болсон шинээр гарч ирэх залгамж халаа нь байхгүй болж байгаа юм. Тиймээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам онлайнаар олгож эхэлсэн нь дэвшилттэй ч тийм ч амжилттай хэрэгжээгүй байна.

Ж: 2017 онд 14 хайгуулын лицензийг цуцаллаа. Энэ ямар учиртай юм бэ?

А. Билгүүн: Үүнийг салбарын яаманд ажилладаг хүн бишийнхээ хувьд мэдэхгүй байна. Лицензүүдийг хараад байхад ихэвчлэн археологийн олдвортой, уурхай болохоор байгаль орчинд хөнөөлтэй гэсэн үүднээсээ цуцалсан юм болов уу гэж харсан.

Ж: Та яагаад эдийн засгаа солонгоруулах бодлого цагаа олоогүй гэж бодож байна вэ?

А. Билгүүн: 2009–2012 оны үед Монгол улсын эдийн засаг хамгийн дээд цэгтээ буюу 17,3 хувьд хүрч хөгжиж буй орнуудыг хөгжлийн тэлэлтээрээ тэргүүлж эхэлсэн. 10 тэрбум долларын 2, 3 гадны хөрөнгө оруулалтууд орж ирж байлаа. Тухайн үеийн бодлого боловсруулагчид, нийт монголчуудын ерөнхий хандлага уул уурхайн салбарт хэт төвлөрөх нь дэмий, эдийн засгийг солонгоруулах ёстой гэсэн бодлого хэрэгжиж эхэлсэн. Гадаадын зах зээл дээр бонд хийж манай засгийн газар нэлээн их хэмжээний өр бий болгосон. Өрөөрөө уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийг

дэмжих хөнгөлөлттэй санхүүгийн хөтөлбөрүүд, үнэ тогтворжуулах хөтөлбөрүүд гэх мэт олон төрлийн төрийн оролцоотой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Ингээд уул уурхайн салбараа хазайлгаад ирэхээр гадны хөрөнгө оруулалтууд алга болчихсон. Сүүлийн 5 жилийн турш бид хямралын байдалтай байлаа. Энэ бол миний бодлоор солонгорох суурь байхгүй эдийн засгийг хүчээр солонгоруулах гэж оролдсон нь алдаа байсан юм болов уу гэж харж байгаа. Хэрвээ бид нар уул уурхайн салбартаа түшиглээд дараагийн Оюу толгой, Таван толгойг нээчих юм бол аяндаа солонгорно гэж бодож байна.

Ж: Солонгоруулахгүйгээр уул уурхайн баялгаасаа яавал монгол хүн бүрт хамгийн өгөөжтэйгээр хүргэж болох вэ? Газар доор байгаа байгалийн баялгийг бидний хэн нэг нь биш байгаль хийсэн учраас бидний хэн нь ч миний хөрөнгө гэж хэлэх эрхгүй. Гэтэл яагаад ч юм хэдхэн хүний хөрөнгө болчихоод байгаа үүнийг та яаж харж байна вэ?

А. Билгүүн: Хамгийн гол нь ил тод байдлын асуудал. Эхний ээлжинд зөвхөн уул уурхайн салбар дээрээ тулгуурлаад яавал Монгол улсад их хэмжээний гадны хөрөнгө оруулалт оруулж ирж, яаж дараагийн уул уурхайнуудыг барих вэ гэдэг асуудлыг нэн түрүүнд тавих шаардлагатай. Тэгэхийн тулд өөрсдийгөө гадаадын хөрөнгө оруулагчдын нүдээр харж үзэх хэрэгтэй.

Гадаадын хөрөнгө оруулагчид манайд ирснээрээ жилдээ 50–100 хувийн хөрөнгө оруулалтын өгөөж шаардаж байгаа бөгөөд үүнийг гаргаж чадах цорын ганц салбар нь уул уурхай, тэр тусмаа хайгуулын салбар байгаа юм.

Ж: Харамсалтай нь монголын хөрөнгийн биржид байгаа компаниудын 5, 6 нь л тайлангаа өгөөд байгаа юм. Жишээ нь

Хонг Конгийн юмуу Торонтогийн хөрөнгийн бирж дээр байгаа компаниуд ил тод байхгүй байж чадахгүй юм байна лээ, яагаад гэвэл цаана нь маш олон хүмүүсийн тэтгэврийн сан явж байгаа, тэгээд ч ил тод биш байвал хасагддаг. Таны ярьж байгаа ил тод хувьцаат компаниуд байлгах аргаар Канад хөгжсөн юм билээ. Эхнээсээ ил тод гарч ирсэн компани нууцлагдмал компаниасаа илүү мөнгө босгож байна. Энэ зарчмыг яаж хэрэгжүүлэх юм бэ?

А. Билгүүн: Та их сонирхолтой өнцөг хөндлөө.

Монголын уул уурхайн компаниуд болон олон нийтэд ил тод гадаадын уул уурхайн компаниудын олон нийттэй харилцах сонирхол нь маш өөр байдаг. Манай компаниуд өөрсдийн олсон нөөцийг аль болох дарах, муу харагдуулах сонирхолтой байдаг байхад гадаадын компаниуд аль болох ордоо гоё болгож харагдуулах дээр ажилладаг. Яагаад гэвэл гоё төслүүдэд илүү их санхүүжилт татах магадлал байдаг. Монголд уул уурхай сайн харагдах юм бол ямар нэг даргын компани очоод авчихна, эсвэл орон нутгийн стратегийн гэсэн нэр зүүдэг байна. Нэгэнт хөрөнгөө оруулчихсан хүний хөрөнгийг хамгаалж чадахгүй байна.

2017.10.25



Дефакто Тойм

Нам гараг бүр, 19:00 цагаас
VTU, Facebook Live

2017.12.03

1. ДЭЛХИЙН БАНК 120 САЯ \$
САНХҮҮЖИЛТ БАТАЛЛАА
2. С.ЗОРИГИЙН ХЭРГИЙГ НУУЦААС
ГАРГАНА
3. БАНКУУДЫН ХӨРӨНГИЙН ДООД
ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭВ
4. Н.ЗОЛЖАРГАЛЫГ БАРИВЧИЛЛАА

ДЕФАКТО ТОЙМ

Долоо хоног бүрийн тойм, jargaldefacto.com/category/12

Нам гараг бүр VTU-ээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2017.12.03-ны дугаар

ДЭЛХИЙН БАНК 120 САЯ ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТ БАТАЛЛАА

Дэлхийн банк Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор 120 сая долларын санхүүжилтийг баталлаа. Уг санхүүжилт нь ашигт малтмалын бус экспортын салбар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, боловсролыг дэмжих, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг олон төслүүдэд санхүүжилт болох юм байна. Энэ санхүүжилт нь улсын төсөвт бага дарамт учруулах бөгөөд Засгийн газрын зүгээс урт хугацаанд өгөөжөө өгөх реформын шинж чанартай төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг олгож байгаа юм. Үүний үр дүнд Дэлхийн банкны зүгээс Монгол улсын эдийн засаг хөгжиж, ядуурал буурах ёстой гэсэн хүлээлттэй байна.

Дэлхийн банкны захирлуудын зөвлөл Олон улсын хөгжлийн ассоциациараа дамжуулан Монгол улсад нийт 600 гаруй сая долларын зээл олгох гэж байгаа юм. Энэ нь ОУВС-ийн өргөжүүлсэн хөтөлбөрт хамрагдаж байгаа ба тэдний нөхцлөөр явбал энэ байгууллагууд нийлээд 5.5 тэрбум ам долларыг босгоно гэж яригдаж байна. Энэхүү 5.5 тэрбум ам.долларын 1.5 нь Хятадын төв банкны Монголбанкинд өгсөн своп зээлийг сунгасан, Азийн хөгжлийн банк эхний хэсгийг өгсөн, Дэлхийн банк 600 орчим сая доллар гаргаж, үлдсэн хэсгийг буюу 1 тэрбум орчмыг Япон, Солонгос гаргах юм.

Энэ зээлийн нөхцөл нь төсвийг дэмжсэн бөгөөд тэр дундаа хөгжлийн бодлогын зээл хэмээн гурван жилийн хугацаатай хөтөлбөрийн өгч байгаа зээл юм. Хөгжлийн бодлогын зээл нь ихэвчлэн

40 жилийн хугацаатай, эхний 15 жилд төлөгддөггүй, дараа нь жилийн 0.75 хувь дээр нэмэх нь либойр буюу Лондонгийн банкуудын хооронд өгч авалцаж байгаа мөнгөний хүүгээр нэмэгдээд их бага болдог. Тэр нь одоогийн 1.5 хувийн хүүтэй болдог зээл гэсэн үг.

Монгол улс энэ удаа Дэлхийн банкны зээлийг хямд зээлээр дарж байгаа. Бонд босгохоороо бид зээлийг үнэтэй зээлээр голдуу дардаг. Тиймээс зээл нэмэгдэж байгаа учраас төр засаг энэхүү зээлийг хэрхэн ашиглаж байгаад иргэд хяналт тавих ёстой. Үүнийг хянах тогтолцоо байхгүй, одоо болтол Дэлхийн банкны хийсэн төслүүдийн бодит үр өгөөж юу болсон бэ гэдэгт иргэдийн дуу хоолой их цөөхөн сонсогддог. Дэлхийн банк дотор хөгжлийн үр дүнг хэмждэг бие даасан хараат бус нэгж байдаг ч үүнтэй цуг иргэний нийгмийн институцууд ажиллах ёстой юм. Монголын төр засаг ил гэдэг ч үнэндээ далд байгаа ийм нөхцөлд биднийг дахин өрөнд оруулж байгаа учраас иргэд хянах ёстой. Дэлхийн банкны вебсайтад монголд 120 сая долларын зээл олгоно, гэхдээ өмнө нь өгч байсан уул уурхайн бусад хөгжлийн, шинэ ажлын байр бий болгох, эрчим хүч, боловсрол, техник холбоо харилцаа, орон нутгийн болон төвлөрсөн засаглалыг хөгжүүлэх тусламж дээр нэмэгдэл болгож өгч байгаа гэсэн мэдээлэл бичжээ. Монгол улсын дуусахгүй байгаа бодлогын өөрчлөлт, шинэчлэлт нь ахиад л ядуурлыг бууруулна гэж байгаа ч ядуурал харин ч нэмэгдээд байгаа гэдэгт Дэлхийн банк юу хэлэхийг сонсмоор байгаа юм. Дэлхийн банк ядуурлаа бууруулаарай гээд мөнгө олгоод байхад ядуурал өсөөд байдаг. Энэ тухай Засгийн

THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUPГэрэл зургийг unaid.org

газар дуугарахгүй, Дэлхийн банкинд ч яагаад өссөн тухай ярьж өгөхгүй байгаа. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны зээл бол хямдхан л болохоос зээл юм. Үүнийг төсөвт хэрэглэнэ гэдэг нь төсвийн алдагдлыг нөхөж байгаа хэрэг л дээ.

Монгол улсын төлөвлөгөөг ярихад их хэцүү, төр засаг нь 1.5 жилийн настай болсноос төлөвлөгөө гэдгийг тоох хүн байхгүй болоод байгаа. Төлөвлөгөө битгий хэл өмнөх засгийнхаа ажлыг ч гүйцээж хэрэгжүүлэхгүй байгаа учраас улс орны эдийн засгийн хөгжлийн талаар авч явуулах арга хэмжээ нь урьдчилан хэлэхэд их хэцүү, үүнээс болж бизнес ч мөн төлөвлөгөөгөө гаргахад хэцүү болж байгаа. 2030 он гэхэд ийм зорилтод хүрнэ гэж дэлхийн орнууд зорилгоо тавьсан байгаа бөгөөд Монгол улс ядуурлыг бүх талаар бууруулсан байна гэж зорьсон.

Дэлхийн банк дэлхийн улсуудын татвараар бусад улсад зээл олгоод л явдаг, үр дүн өгч байгаа юу? үгүй юу? гэдэгт тухайн улсын Засгийн газартай хангалттай ярьж чаддаггүй.

С.ЗОРИГИЙН ХЭРГИЙГ НУУЦААС ГАРГАНА

С.Зоригийн хэргийн материалыг төрийн нууцаас хэсэгчлэн гаргах шийдвэрийг ЗГ гаргалаа. Уг шийдвэрээр нийтдээ 14926 хуудас материалыг ил болгох шийдвэр гарсан. Энд хэргийн захиалагчтай холбоотой асуудал ороогүй бөгөөд нийтдээ 74 хуудас материал нууц хэвээр үлдэхээр болсон байна. Юуны өмнө энэ нь ТЕГ-ын дарга асан Б.Хурцын мэдэгдэлтэй холбоотой. Б.Хурц хэлэхдээ Ц.Нямдорж сайдыг С.Зориг агсны хэргийг нуун дардаг гэсэн. Ц.Нямдорж сайдын хэлсэн мэдэгдэл нь “бөөрөнхий”, Засгийн газрын шийдвэр ч “бөөрөнхий” байгаа юм. Хэдэн хуудас хавтаст хэргийг төрийн нууцаас гаргах нь бидэнд сонин биш, харин захиалагчтай холбоотой 74 хуудас нь нууц хэвээр үлдэх юм гэнэ.



NEW NISSAN

PATROL



ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа 0%

Хүү 1.4%

Хугацаа 84сар

УРАМШУУЛАЛ:

XPEL

Хамгааллын хууль

3 200,000

Салбар

4ш

Өвчлөн дугуй

LUMMA

Саломын шийн хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

Хамгийн гол зүйлээ хэлэхгүй юм бол үүнийг нээсэн ч, байсан ч ялгаагүй. 20 жилийн өмнө улс төрийн өндөр албан тушаалтан хүн алагдсан байдаг, түүний амийг бүрэлгэсэн гэх этгээдүүд хариуцлага хүлээн 20-оод жилийн ял авчихсан байдаг, иргэд харин захиалсан хүмүүсийг нь мэдэхгүй байна. Ингээд үзэхээр төр засаг биднийг дамшиглаад байгаа байхгүй юу. Хоорондоо ямар учиртай гэдэгт бүр их сэжиглэж байгаа, Ц.Нямдорж байна уу, Б.Хурц байна уу тэр бол техникийн асуудал. Тийм том албан тушаалтай хүнийг захиалагчийг нь нуугаад бүрэлгэчихэж чадаж байгаа юм бол над шиг хүмүүсийг “ялаа” шиг алах нь л дээ.

Ц.Нямдорж сайд амласнаа биелүүлээд бүгдийг нь ил болгох хэрэгтэй. Зүгээр л Б.Хурцын өмнө асуудлыг ил болгодог гэдгээ батлах гэж байгаа юм бол тийм зүйл бидэнд хэрэггүй.

Иймэрхүү жүжиг монголд хангалттай болсон ба ийм дуусдаггүй жүжгийг хамаар байгаа юм. Статус нь өөр болсон учраас Улсын дээд шүүхийн архивт шилжинэ гээд байгаа ч бидэнд түүний статус гэх зэргийн техникийн асуудал хамаагүй. Хаана ч байсан ил тод л болгохгүй юм бол хавтсаа хаашаа зөөх нь сонин биш.

Дээд шүүхийн хяналтын шүүхээр 5 шүүгчээр орсон ба үүнд дээд шүүхийн ерөнхий шүүгч өөрөө орсон байгаа юм. Энэ шүүх засаглал гэдэг чинь учраа мэддэггүй юмуу, санаатай биднийг доромжлоод байна уу. Ерөнхий шүүгч яахаараа ч хяналтын хөндлөнгийн шүүхэд оролцоод явж байдаг юм.

Улс төржсөн асуудлын цаана Монгол улсын шүүх засаглал, шударга ёсыг тогтоох засаглал ажиллахгүй байна.

Монголын ардчиллын 2 үндсэн тулгуур юм байдаг. Нэг нь сонгодог, нөгөө нь хянадаг. Энэ хянах үйл явцыг ажиллуулахгүйн төлөө сонгуулсан нөхөд бүх чадлаараа хичээж ирсэн. Монголын ардчиллын ажиллахгүй байгаа гол шалтгаан нь нууц гэдэг нэрээр төр засгийн хүмүүс шүүх засаглалыг хүссэнээрээ өөрчилж болж байгаад хамаг учир нь байна.

БАНКУУДЫН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭВ

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10-р сарын 30-ны өдрийн шийдвэрээр банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөс 100 тэрбум төгрөг

болгожээ. Монголбанкны мэдэгдсэнээр энэ шийдвэр нь арилжааны банкуудад хийж буй активын чанарын үнэлгээтэй холбоогүй гэнэ. Монголбанкны зүгээс банкуудын эрсдлийг бууруулах зорилготой ийм шийдвэр гаргасан гэж тайлбарласан.

Монголын банкууд хоорондоо том жижиг гэж байгаа боловч, үндсэндээ жижиг банкууд шүү дээ. Тэр жижиг банкуудаар гадаадын томоохон төсөл дамжихгүй байгаа нь дамжуулж чадах хэмжээний өөрийн хөрөнгөгүй байгаад юм. Монголын банкуудын лобби их сайн байгаа, ялангуяа жижиг банкуудын лобби. Монголын жижиг банкууд бол хүүг өсгөж байдаг хүчин зүйлийн нэг, үүнийг Төв банк хэлдэггүй. Жижиг банкууд ББСБ-ын хэмжээнд л яваад байгаа, төрийн үйл ажиллагаа том болох тусам жижиг банк руу байршуулах данс нэмэгдээд байгаа. Энэ 2 нам ээлжлээд л өгөшүүлээд байгаа нь монголын улс төрчид банкуудын санхүүжилтээс их хамааралтай байгаад юм. Өөрсдөө эсвэл ах дүү, хамаатан садан нь зээлтэй байгаа, голдуу их хүүтэй учраас ихэвчлэн л асуудалтай байгаа. Түүгээр нь барьцаалсан монголын банкуудын дуу хоолой хүчтэй байгаа гэдгийг харуулж байна. Өөрийн хөрөнгө бага байхад банк томрохын тулд нийлэх юмуу, бие биенээ худалдаж авдаг. Тэгэхийн тулд банкуудын актив болох сайн муу зээл нь тодорхой, олон улсын стандартын, хөндлөнгийн хүн хараад ойлгохоор байх ёстой. Гэтэл тийм биш байна гэж ОУВС үзээд бүх арилжааны банкуудын активынх нь үнэлгээг дахиж хийж байгаа шүү дээ. Үүнийг жил бүр хийдэг энгийн гэж Төв банк хэлж байгаа ч үнэндээ бол энгийн зүйл биш.

100 тэрбум болгож байгаа нь зээл олголтод нөлөөлөхгүй, 2021 онд улс төрчид бүгд өөр, Төв банкны захирал нь ч солигдоно. Өөрсдөдөө ямар ч хамаагүй хол хугацаа тавьж байгаа юм.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ АСАН Н.ЗОЛЖАРГАЛЫГ БАРИВЧИЛЖЭЭ


Энэ тал дээр хэлэх болоогүй л дээ, хараат бус шүүх засаглал нь хэлэх ёстой. Гэвч одоогоор хараат бус биш гэдгийг нь бид харж байгаа. Шүүхийн бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч сольж эхэлсэн байгаа. Монголбанкны Ерөнхийлөгч гэдэг маш том албан тушаал, хэрвээ тэр хүн буруутай юм бол яагаад маргааш нь суллагдсан юм, хэрвээ тэр хүн буруугүй

юм бол яагаад баривчилсан юм.

Монгол улсын Ерөнхийлөгч байсан Н.Энхбаяр гэдэг хүнийг хүчээр баривчлаад аваад явж байсан. 5 зүйлээр буруутгаснаас 1 жилийн дараа 2 нь алга болж 2 жилийн дараа ялгүй болсон шүү дээ. Тэр хүн ер нь юу хийгээд баривчлагдсан юм гэдэг нь асуудал. Яагаад МУ Ерөнхийлөгч байсан хүнээ баривчилсан юм бэ? Буруутай бол юуг нь буруутгасан юм, үнэхээр буруу юм бол яагаад цагаатгасан юм. Н.Золжаргалын тохиолдол яг ийм асуудал л даа.

Хэрвээ үнэхээр Монголбанкны Ерөнхийлөгчийн гаргасан бодлого нь алдаатай байсан бол ажлын хариуцлага, харин ажлаа хийх явцдаа хувьдаа завшсан бол өөр асуудал. Орон сууцны хөнгөлөлттэй зээл үнэхээр зөв байсан бол яагаад Монголбанк түүнийг үргэлжлүүлж чадахгүй, төсөв рүү шилжүүлээд байгаа юм бэ. Төсөв рүү энэ бодлого шилжчихвэл та бидний цалингийн 4-ний 1-ээр үүнийг санхүүжүүлээд, хүрэхгүй бол дотооддоо бонд босгоно гэж байна. Тодорхой цөөхөн хэсэг хүмүүс байр авахын төлөө бүх хүмүүс яагаад төлөх ёстой юм бэ гэдэг асуулт гарч ирнэ. Энэ бодлого буруу байсан гэдгийг гарсан өдрөөс нь эхлэн би ярьсан.

2 шатлалтай банкны систем байгуулахдаа бид Монголбанкны Ерөнхийлөгчид эрх мэдлийг өгсөн ч үүний хажуугаар төр засгаас хол байх, хамаатай бус байх үүргийг өгсөн. Ингэснээр энэ хүн төр засаг бонд гаргавал бий болох инфляцийг би хариуцахгүй гэж ярих боломжтой болж байгаа юм л даа. Монголбанкны үүрэг бол арилжааны банкаа хянаад, нөгөө талаас инфляцийг барих юм.



Гэрэл зургийг news.mn

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh17-12-sh3> холбоосоор үзнэ үү.